

NEW MONGOL
БАТЛАВ
ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Т. Доржпал ОЮУНЖАРГАЛ
2026 оны 03 дугаар сарын 20
ШИНЭ МОНГОЛ
ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ
УЛААНБААТАР

ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН НЭРЭМЖИТ БАЙГАЛИЙН УХААНЫ VII ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

Нэг. Олимпиадын зорилго

ЕБС-ийн 9 дүгээр ангийн сурагчдад байгалийн ухааны хичээлүүдээр суурь мэдлэг чадвараа сорих боломжийг олгохын зэрэгцээ ирээдүйд инженер болох хүсэл зорилготой өсвөр үеийнхнийг дэмжихэд оршино.

Хоёр. Олимпиадын ангилал ба агуулга

2025-2026 оны хичээлийн жилд зохион байгуулж буй байгалийн ухааны 7-р олимпиад нь дараах ангиллаар зохион байгуулагдана.

1. Математик, физик (Математик 60%, Физик 40%)
2. Математик, хими, биологи (Математик 60%, Хими 25%, Биологи 15%)

Гурав. Хугацаа, байршил

Олимпиад 2026.04.25-ны өдрийн 10:00 – 12.30 цагт ШМТК-ийн байранд болно.

Дөрөв. Оролцогчид ба Бүртгэл

Тус олимпиад нь 2025-2026 оны хичээлийн жилд ЕБС-ийн 9-р ангид сурч буй бүх суралцагчдад нээлттэй бөгөөд бүртгэлийн хураамж 5000 төгрөг.

Олимпиадад оролцогчдыг 2026 оны 04-р сарын 2-ноос 04-р сарын 23-ны 18:00 цаг хүртэл ШМТК-ийн фэйсбүүк хуудсанд байршуулсан бүртгэлийн холбоосоор бүртгэнэ.

Фейсбүүк хуудас: New Mongol KOSEN "Шинэ Монгол Технологийн Коллеж"

Тав. Зохион байгуулалт

Олимпиад зохион байгуулагдах өдөр буюу 2026 оны 04 сарын 25-ны өдрийн үйл ажиллагаа дараах хуваарийн дагуу зохион байгуулагдана.

Цаг	Хийгдэх зүйлс	Байршил
09:30 - 09:50	Бүртгэл, анги хуваарилалт	ШМТК, 1 давхарт
10:00 - 12:30	Олимпиадын бодолт	ШМТК-ийн анги, танхимууд
11.40 – 16.00	Сургуулийн орчин, үйл ажиллагааны танилцуулга	ШМТК-ийн лабораториуд, анги танхимууд
12:40 – 13.10	Коосэн хөтөлбөрийн онцлог, инженерийн боловсрол, ШМТК-ийн танилцуулга яриа	809 тоот

Зургаа. Шагнал, урамшуулал

Олимпиадын ангилал тус бүрээр 1-3-р байр, тусгай байрыг шалгаруулж, шагналт байранд орсон сурагчдыг Шинэ Монгол Технологийн коллежид 2026-2027 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн 10-50%-ийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг, дурсгалын зүйл, мөн амжилттай оролцсон тодорхой тооны сурагчдыг ШМТК-д бичгийн шалгалтгүй элсэх эрхийн бичгээр шагнаж урамшуулна. Үүнд:

А. Математик, физикийн төрөл:

- I байр - 1 сурагч, медаль, сургалтын төлбөрийн 50%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- II байр - 2 сурагч, медаль, сургалтын төлбөрийн 30%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- III байр - 3 сурагч, медаль, сургалтын төлбөрийн 20%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- Тусгай байр - 4 сурагч, сургалтын төлбөрийн 10%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- Амжилттай оролцсон 20 сурагчдад (11-30-р байр) бичгийн шалгалтгүй элсэх эрхийн бичиг (Компьютерийн ухаан, Цахилгаан электроникийн инженер, Механикийн инженер, Барилга, дэд бүтцийн инженер ангиудаас сонголтоор)

Б. Математик, хими, биологийн төрөл:

- I байр - 1 сурагч, медаль, сургалтын төлбөрийн 50%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- II байр - 1 сурагч, медаль, сургалтын төлбөрийн 30%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- III байр - 1 сурагч, медаль, сургалтын төлбөрийн 20%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- Тусгай байр - 2 сурагч, сургалтын төлбөрийн 10%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг
- Амжилттай оролцсон 10 сурагчдад (6-15-р байр) ШМТК-ийн Химийн инженерийн ангид бичгийн шалгалтгүй элсэх эрхийн бичиг (Анхаарах: Химийн инженерээс бусад ангийг сонгох бол эрхийн бичиг үйлчлэхгүй)

Долоо. Шалгаруулалт ба шагнал гардуулалт

Олимпиадын дүнг тухайн өдөртөө багтааж ШМТК-ийн фейсбүүк хуудсаар мэдээлнэ. Шагналт байр эзэлсэн сурагчдад шагналыг 2026 оны 04 сарын 27-ны өдрийн 15.00 цагаас ШМТК-ийн 809 тоотод гардуулна.

Найм. Хаяг байршил, холбоо барих мэдээлэл

Хаяг: УБ хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Шинэ Монгол Технологийн коллеж

Утас: 7577-7799

Сургуулийн фэйсбүүк хуудас: New Mongol KOSEN "Шинэ Монгол Технологийн Коллеж"

БОЛОВСРУУЛСАН:

МАТЕМАТИК, ФИЗИКИЙН ЗААХ АРГЫН НЭГДЛИЙН БАГШ *Б.Сэлмаа* Б.СЭЛМАА